



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

“Бодь даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Бодь даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн 2013 оны хуримтлагдсан ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгийн ногдол ашгийн мөнгөн хөрөнгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Л.Болд	1 350 162 600,00	367 500 000,00	1 717 662 600,00	49%
2	Л.Болдхуяг	1 400 380 400,00	382 500 000,00	1 782 880 400,00	51%
	Дүн	2 750 543 000,00	750 000 000,00	3 500 543 000,00	100%

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2015 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Бодь даатгал” ХХК /Д.Болормаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000517